

СЭТГҮҮЛ ЗҮЙН ТУУРВИЛЫН ХЭЛ НАЙРУУЛГЫН ЗАРИМ АСУУДАЛ

Л.Норовсүрэн*
Х.Энхтуяа**

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, шинжлэх ухааны доктор (Sc.D.), МУИС-ийн профессор

** "Отгонтэнгэр" их сургуулийн Сэтгүүл зүйн тэнхмийн эрхлэгч, докторант

Түлхүүр үг: даяаршил, мэдээллийн хэрэгсэл, хэл найруулга, төрийн бодлого, дархлаа

Даяаршлын эрин үед бага буурай улс үндэстнүүдийн өмнө тулгарч байгаа бэрхшээлтэй асуудлын нэг нь үндэсний хэл соёлоо хамгаалах зорилт болж байна. Энэ асуудал нэг улс үндэстний хүрээнээс аль хэдийнээ хальж нийт хүн төрөлхтний сэтгэл зовоосон асуудал болжээ. Үүний тодорхой жишээ нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын санаачилгаар 2008 оныг дэлхийн олон улсын эх хэлний жил болгон зарлаж, түүний төрөлжсөн байгууллага — ЮНЕСКО «Хэлний хамтлаг бүхэн өөрийн эх хэлийг аль болохоор өргөн, байнга, түүний дотор боловсролын салбарт ашиглахад чиглэсэн хэлний бодлогыг хөгжүүлэх»-ийг уриалсан явдал мөн.

Орчин үед үндэстний дархлааг тогтоох цорын ганц арга нь тэдгээрийн хэл ба соёлыг хамгаалах явдал гэдгийг нийтээрээ мэдэх болжээ. Тиймээс ч ЮНЕСКО «Соёлын олон төрлийг хамгаалах аргаар үндэстнийг аварна» гэсэн бодлого явуулж байгаагийн дотор дэлхийн олон хэлийг хамгаалах санаа багтаж байгаа юм.

Дэлхийн олон үндэстний хэлийг хамгаалах асуудал аль хэр чухал болж

байгааг дараах тоо баримт харуулна. 2005 онд АНУ-ын хэл шинжлэлийн институтээс гаргасан тооцоогоор дэлхий дээр 6912 хэл байгаа аж. Тэдгээрийн 6712 хэлээр нь дэлхийн хүн амын ердөө 6,0 хувь нь ярьдаг байна. Гэтэл хүн төрөлхтний 94 хувь нь ердөө л 242 хэлээр ярьдаг аж¹. Үүнээс үзэхэд дэлхийн хүн амын үнэмлэхүй олонх нь даяаршлын давалгаанд арчигдахын даваанд тулж очсон жижиг хэлээр ярьдаг нь тодорхой байна. Тэдгээр жижиг хэлнээс жил тутам 10-20 орчим нь устаж байгаа гэсэн тооцоо ч байдаг.

Эрдэмтдийн үзэж байгаагаар хэл мөхөхөд нөлөөлдөг хоёр том шалтгаан байгаагийн нэг нь тухайн хэлийг сургуульд заадаггүй байх, нөгөөх нь уг хэлээр зөвхөн ахмадууд яриад залуу үеийнхэн ярихаа болих явдал аж. Бидний төрөлх хэлний хувьд энэ хоёр шалтгааны аль аль нь байхгүй боловч тайвшрах үндэслэл биш юм. Хүн төрөлхтний нийтлэг жишгийг даган хөгжлийн шинэ замдаа орж, тэр хэрээр олон улсын нэр хүнд нь өсч, сэргэн мандаж байгаа монгол үндэстэн-бидний хэлийг дав даруйд мөхөөх шалтгааныг гаднаас эрэхийн өмнө өөрсдөөсөө хайх хэрэгтэй болоод байна.

Юуны өмнө бид харийн соёлын өмнө сайн дураараа буун өгч, үндэстний дархлаа болсон төрөлх хэл,

соёлоо хамгаалж, хөгжүүлэхэд бага анхаарч байгааг тэвчих аргагүй юм. Шинжлэх ухаан, технологийн дэвшлийг амдаж ашиглах, харь хэлийг сурч эзэмших гэдэг нь хэрэгцээ болохоос, хээнцэрлэл биш юм. Ганц нэг гадаад хэл гадарлачихаараа үндэсний хэл, соёлоо гэх сэтгэлээ гээчихдэг дутагдал монгол соёлыг ирээдүйд улаалан авч явах үүрэгтэй залуу үеийнхний дотор цөөнгүй байгаа нь харамсалтай.

Агуу их Инжиннаши нэгэнтээ «Нэгэн хоёр иргэн үсэг таниваас даруй монгол үсгээ басамжлан, монгол үсгээр иргэний санааг бүртгэн гаргаж хэрхэн чадмуй хэмээн амны аяар чалчмуй. Энэ нь далайн хөвөөнд биеэ угаагаад далайг гүехэн үзсэнээс юун өөр буй»² хэмээн бичиж байсан нь өнөөдөр ч сургамжтай хэвээр байна.

Юу гэх гээд байна гэхээр монгол бичгийн хэл гадаад хэлний нөлөөнд их автаж байна гэж хэлэх гэсэн юм. Хоёр зүйлийн муу нөлөөг нэрлэж болно. Нэгдүгээрт: Гадаад хэлний өгүүлбэрийн бүтцийг хуулж, монгол хэлний уламжлалт найруулгын тэгийг эвдэх эндэгдэл их байна. Барагцаалбал өнгөрсөн зууны наяд оноос эх үндсээ авсан энэ үзэгдлийг “харийн бичгийг монгол үгээр хуулах” гэж нэрлэж болмоор санагддаг. «Ач холбогдол өгөх», «Энэ утгаараа», «Зөрчил гаргасан тохиолдолд торгоно», «Усжуулах замаар ургац нэмэгдүүлнэ» гэх мэтээр ярьж бичих болж.

Монгол хүн хэзээнээсээ ингэж ярьж, бичиж байгаагүй. Энэ нь өнгөц харахад монгол хэлээр ярьж, бичээд байгаа юм шиг хэрнээ цаагуураа мөхөөх суурь дэвсгэрийг тавиад байгаад л хамаг гэм байгаа юм. Гадаад хэлний өгүүлбэрийн бүтцийг хуулсан энэ мэт найруулгыг амьдрал ахуйн энгийн үг хэллэгтэй жишээд үзэхэд үнэхээр инээдэмтэй сонсогдоно. Үлгэрлэвэл «Зун болсон нөхцөлд амарна», «Хоол идэх замаар цадлаа» гэж ярих болж байна. Зүй нь «Зөрчил гаргавал торгоно», «Усжуулж ургац нэмэгдүүлнэ» гэх ёстой бөгөөд,

ингэж ярьж, бичих нь наанадаж монгол хэлээ эвдэхгүй, цаанадаж эдийн засгийн хувьд ч хэмнэлттэй юм. Улс төрийн ардчилсан тогтолцоог сонгож, зах зээлийн эдийн засагт шилжсэнээр улс орны гадаад харилцаа хөгжиж, тэргүүний технологи нэвтрэх зэрэг эерэг сайн зүйлүүд олон гарч байгаа боловч, нөгөө талдаа гадаадын соёлын түрэмгийлэлд өртөх эрсдлийг дагуулах болсон нь өнөө үеийн анхаарууштай асуудлын нэг болж байна. Нэгэн үед оросоос өөр хэл мэддэггүй, мэдэх орчин ч үгүй байсан монголчууд өнөөдөр дэлхийн аль ч өнцөгт хүрч сурч, ажиллаж, аж төрөх болов. Тэдний хүүхэд багачууд харь хэлээр “амлаж”, харь оронд өсч торниж байна. Төрөлх хэл, соёлоосоо хөндийрсөн тийм хүмүүсийн тоо бараг хагас саяд хүрчээ.

Хэл “эрлийзжих” бас нэг шалтгаан нь гадаад хэлний үгийг бодлогогүй хэрэглэсэнтэй холбоотой юм. Хуучин тогтолцооны үед Сайд нарын Зөвлөлийн дэргэд Улсын нэр томьёоны комисс гэдэг байгууллага байв. Хэлний эрдэмтдээс голчлон бүрдсэн тэр байгууллага гаднаас орж ирсэн үгийг бүртгэн, ямар үгийг яаж хэрэглэж хэвшүүлэхийг тогтоож, жил бүр гардаг «Улсын нэр томьёоны комиссийн мэдээ»-гээр зарладаг байлаа. Хорь гаруй жилийн өмнөөс тэр уламжлал унтарсан. Тэр сиймхийгээр, тухайлбал ерээд оноос монгол хэл гадаад үг үржих шимт хөрс болж хувирсан билээ. Энэ үеэс элит, лидер, популист, парламент, жентельмен, мисс, бирж, брокер, компани, шоу, ломбард, компьютер, босс, эротик, секс, теле-шоф, рейтинг, бакалавр, рок поп, коллеж, модерн, реклам, дизайн, факс гэх мэт үй олон үг хэллэг түрэн орж ирсэн. Гадаад үг орж ирэх нь хөгжлийн зүй ёсны үзэгдэл юм. Харин тэдгээрийг төрөлх хэлэндээ яаж идээшүүлэх вэ гэдэг нь гол асуудал мөн.

Наяд онд орос хэлнээс “маратория”, “застойнство” гэх мэт шинэ үг хэллэг орж ирэхэд “азнах”, “зогсонги

байдал” гэх мэтээр орчуулан хэрэглэсэн нь хэвлэл мэдээлэл, хүмүүсийн харилцаанд дорхноо хэвшиж байсан. Түүн шиг дээр дурдсан үгсийн нилээд хэсгийг орчуулж хэрэглэхэд монгол хэлний үгсийн сан дутна гэж лав байхгүй. Бид гадаад үг орохоос учир шалтгаангүй цэрвэх гээгүй. Жишээ нь бирж, брокер, бакалавр, компани, ломбард, факс, компьютер гэх мэт олон улсын чанартай үг хэллэгийг хэвээр нь хэрэглэхийг буруутгах шалтгаан байхгүй. Гэтэл мисс — гоо бүсгүй, лидер — манлайлагч, популист — нэр төр хөөцөлдөгч, секс — бэлгийн харьцаа, женгельмен — дэгжин эр гэх мэтээр хэвшүүлэхэд болохгүй гэх газаргүй юм.

Хоёрдугаарт: гадаад хэлний үгийг төрөлх хэлтэйгээ хольж ярьж, бичих хээнцэрлэл хэрээс хэтэрлээ. Энэ гажуудал газар авсаар нийтлэл, нэвтрүүлгийн хэл олон хэлний холимог болсны дотор орос, англи үг төрөлх хэлний үгсийн санг улам бүр мэрэн идсээр байна. Ингэж, бичиж ярьдгийгаа олон газар явж, юм үзэж нүд тайлсан боловсролтой хүний шинж, бусдаас өөрийгөө ялгаруулах хэрэглүүр гэж эндүүрдэг сэхээтэн олширсон нь нууц биш юм. “Муу дээр улцан нэмэр” гэгчээр гадаад үгээ ч зөв биччихэж чаддаггүй “бичээч” олон байна. Жишээ нь «Өнөөдөр» сонин нэгэн нийтлэлээ «Хийсвэр хийлгэх нь сөрөг үр дагавартай юу?» гэж гарчигласан байх юм. Кесарев гэдэг хүн эхийн хэвлийд мэс засал хийж төрүүлэх анхны туршилтыг хийснээс хойш Кесаревын аргаар төрүүлэх гэсэн нэр томьёо үүссэнийг энэ хүн мэддэггүй бололтой. Үнэндээ “хийсвэр” гэдэг нь хүн төрөхөд ямар ч утга, холбогдолгүй үг юм.

«Монголын нэг өдөр» сонин «Энэ ямар хүн бол, манай Батбаярын дэмжигч балешик нь...» гэж бичжээ. «Балешик» гэдэг үгээ ч зөв бичиж чадсангүй. Энэ үгийг “дэмжигч” гэдэг үгтэй хавсарч хэрэглэсэн байхыг бодвол утгыг нь ч мэдэхгүй байгаа бололтой. Дашрамд тэмдэглэхэд уг үгийг манай-

хан “балиашик”, “балившик” гэх мэтээр бичсэн нь энд тэнд үзэгддэг.

Мэддэг атлаа хэлийг зориуд буртаглагчид байхад, мэдэхгүйгээсээ болж ядууруулдаг нэг хэсэг байна. Сэтгүүлчдийн төрөлх хэлний боловсрол маш муу байгаа нь нүдний өмнө ил байна. Энэ нь ерөнхий боловсролын сургуулийн хэл, уран зохиолын сургалт муу, салбартаа гол хүч болж байгаа залуу сэтгүүлчдийн үзсэн уншсан нь бага учраас үгсийн сан, найруулах чадвар хомс байдаг зэрэг олон шалтгаантай. Сэтгүүл зүйн туурвилын хэл найруулгын алдааны зонхилох хэсгийг үгсийн сангийн болон хэлний зүйн найруулгын алдаа эзэлж байна. Энэ төрлийн алдаа сонин, сэтгүүлд гардаг нийт алдааны 80,0 орчим хувийг эзэлж байгааг судалгааны дүн харуулсан юм. Хэл найруулгын алдаанд үгийг буруу байрлуулах, үг давтах, олон тооны дагаврыг давхардуулах, үйл, нэрийн нөхцлийг буруу хэлбэршүүлэх, үг илүүдүүлэх, дутаах алдаа хамгийн их байна.

Монгол хэлийг ядууруулж байгаа гол буруутнаар телевиз, сонин хоёр тодорч байгааг эрдэмтэн мэргэд төдийгүй, энгийн иргэд хүртэл ярьж шүүмжилж байгаа. Энэ нь ажиглаад үзэхэд ил байна. Сэтгүүлчийн туурвилын үндэс нь эх бичвэр юм. Гэтэл манайхан эх бичвэр гэдэг ойлголтоо ч сайн мэдэхгүй байх шиг байдаг. Эрдэмтэн судлаачид «Хэлэхийн тодорхой нөхцлийн хүрээнд бодит байдлыг цогцолбороор илэрхийлэх хэлний төгс дохио»³, «Утга санаа болон хэл зүйн нэгдлээр илэрч байгаа өгүүлэхийн нэгж»⁴, «Өгүүлбэрийг учир зүйн дарааллаар холбон санаагаа илэрхийлсэн өгүүлбэрийн дээд төвшинд хамаарах хэлшинжлэлийн нэгэн салбар»⁵ гэх мэтээр тодорхойлж байна. Онолын энэ мэт томьёоллыг бүтээл туурвилдаа харгалзан үзэх талаар сэтгүүлчид дутмаг байдаг. Манай телевизүүд «Казахстаны Ерөнхийлөгчийн сонгуулийг 1000 орчим олон улсын ажиглагч ажиглав» (TV-9

телевиз, “Энэ өдөр”, 2005.12.05), «Аляскт 30 настай цанаар гулгаж байсан нэгэн эр их цасанд дарагдаж нас баржээ» (МҮОНТ), «Сиднейд үзэл бодлын зөрөөнөөс болж мөргөлдөөнд 5000 орчим хотын иргэн оролцжээ» (MN-25 суваг, “25 цаг”, 2005.12.12), «Өвлийн олимпийн анхны тоглолт 1932 онд АНУ-ын 4000 гаруй жижигхэн хүн амтай хотод болжээ» (TV-5 телевиз, 2005.12.18) «3000 орчим Курдын босогч нуугдаж байна» (С-1 телевиз, “Фокус”, 2007.10.12), «Наян настай Куба улсын тэргүүн Фидель Кастро» (SBN телевиз, “SBN news”, 2007.10.15), «Фтор кальц агуулсан шүдийг гаднын нөлөөгөөр бохирдохоос хамгаалах PS оо» (TV-9 телевиз, Реклам, 2005.12.19) гэх мэтээр ярьж байна. Үгийн байрыг олж тавиагүйгээс үүдсэн алдаа заримдаа инээдэмтэй, бас эмгэнэлт байдалд хүргэдэг. Жишээ нь «100 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэд» (UBS телевиз, “Citi news”, 2005.12.12) гэснийг уншсан хүн “хөгжлийн бэрх-шээлтэй 100 гаруй иргэн” гэж ойлгохоосоо илүү “Хөөрхий дөө. Ёстой л зовлонгийн үүр уурхай болсон улс юм даа” гэж бодох байх. Нэг хүнд 100 гаруй бэрхшээл тулгарсан хойно аргагүй шүү дээ. Энэ мэт алдаа бүхнийг тайлбарлах нь илүүц биз.

Телевизүүд «Шийдвэрлэвэл зохих шийдвэрүүдийг шийдвэрлэсэн байна» (TV-9 телевиз, “Энэ өдөр”, нэвтрүүлэгч Болорчимэг, 2005.12.19), «Цахилгаан таслах арга хэмжээ авсантай холбоотой» (TV-9 телевиз, “Энэ өдөр”, 2007.10.16) гэх мэтээр нэвтрүүлж байна. Үг давтах, илүүдүүлэхийн үүнээс

өөр сонгодог жишээг хаанаас олох билээ. Эхний алдаа найруулах чадвар дутсанаас болсон бол, хоёр дахь нь албаны сүржин үг хэллэгийг шууд авч хэрэглэснээс үүдсэн алдаа байна. Манай сонин, телевизэд “айлчлах” гэхийг “айлчлал хийх”, “хоцрогдох” гэхийг “хоцрогдолд орох”, “хэрэг бүрдүүлэх” гэхийг “хэрэг бүрдүүлэлтийн ажиллагаа явуулах” гэх мэтээр албаны сүржин үг хэрэглэж нурших алдаа түгээмэл байна. Ямар ч хэлбэрээр

«

*Улс төрийн ардчилсан тогтолцоог
сонгож, зах зээлийн эдийн засагт
шилжсэнээр улс орны гадаад харилцаа
хөгжиж, тэргүүний технологи
нэвтрэх зэрэг эерэг сайн зүйлүүд олон
гарч байгаа боловч, нөгөө талдаа
гадаадын соёлын түрэмгийлэлд өртөх
эрсдлийг дагуулах болсон нь өнөө
үеийн анхаарууштай асуудлын нэг
болж байна.*

»

сониныг 40 мянган хувь хэвлэхэд ямар ч хэрэггүй хоёр сая үг хэвлэхэд хүрэх аж. Энэ тухайд «Мастер бол хэзээ ч мастер байх ёстой. Сар тутмын сэтгүүлд сайн бичсэн хэрнээ долоо хоног тутмын хэвлэлд муу бичиж болохгүй. Роман бичихдээ гараа гаргасан мөртлөө найруулалд болохоор хүчээ төдий л шавхахгүй байх ба сонины өгүүллийг бол бүр гар хурууны үзүүрээр бичдэг байж болохгүй»⁶ гэсэн К.А. Фединий үгийг санахад илүүдэхгүй.

Зөв өгүүлэхийн хэм хэмжээг зөрчсөн алдаа сэтгүүлчдийн бичвэр болон үг ярианд цөөнгүй тааралддаг. «Эхлээд пивоо хийгээд амтлагч нараа холиод халуун чулуу хийж, хүнсний ногоогоороо бүрээд...» гэж бичих юм. Амьгүй

юмсад олон тооны "нар" дагаврыг хэрэглэдэггүй билээ. "Ах, дүү нар" гэвэл хэвийн сонсогдоно. Харин "тамээ, адуу нар" гэвэл яавч олигтой сонсогдохгүй.

Нэг сонинд «Би 21 настай, эмэгтэй. Их сургуульд сурдаг. Урьд нь гэрлэж байгаагүй» гэсэн байхад, телевизээр «"Сэрэлт оч" кино театрт "Нөхөрт гараагүй эрчүүд" гэдэг кино гарна» гээд зарлаж байх юм. Энэ хоёр өгүүлбэрийг уншиж, сонсоход хүүхнүүд нь өргөө гэрээ босгоод эрчүүдийг оруулж авдаг болсон юм болов уу гэж бодмоор. Эрчүүд нөхөрт гарна гэвэл хоёр эрэгтэй хүн л хоорондоо сууна биз дээ. Сүүлчийнх нь мэдээж хошин шог бүтээлд өгсөн марзан гарчиг байх л даа. Гэхдээ ийм этгээд үг хэллэг яваандаа шилжсэн утгаа гээж буруу ярьж, бичих гэмд хүргэдгийг анхаарахад илүүдэхгүй юм.

Хэвлэл мэдээллийн нийтлэл, нэвтрүүлэгт баримтын алдаа захаас аван гарч байдаг. «Өнөөдөр» (№177) сонинд нийтлэгдсэн нэгэн өгүүлэлд «Чехов Монрог маш ичимтгий гэж дүгнэж байжээ», «Михайл Чеховын "Эгч, дүү гурав" роман» гэсэн хоёр өгүүлэмж байна. Нягтлаад үзвэл баримтын бөөн алдаа. Нэгдүгээрт: Чехов 1904 онд нас барсан. Харин Монро 1926 онд төрсөн. Ингэхээр Монрогийн ичимтгий занг Чехов мэдэх ёсгүй. Хоёрдугаарт: «Эгч, дүү гурав»-ыг Михайл Чехов биш, Антон Павлович Чехов бичсэн. Гуравдугаарт: «Эгч, дүү гурав» роман биш, жүжиг юм.

«Өнөөдөр» (2001.12.02) сонинд нэгэн материалдаа «Ноён архи та нохойгоо хорино уу?» гэсэн гарчиг өгсөн байв. Яаж бодсон ч зөв сэтгэхүйн алдаатай гарчиг юм. Архи хүний аман луу өөрөө урсаж орохгүй. Тэгэхээр архийг биш, харин архичны донг хоримоор санагдана. Сурвалжлагч Баяржаргалын асуултанд яруу найрагч Б.Лхагвасүрэн «Би ч одоо асуулт бүхэнд сөглүүлсээр байгаад буйл нь сэтэрхий тэмээ шиг болчихсон» гэж хариулжээ. Тэмээний хамар сэтэрдэг,

буйл сэтэрдэггүй. Уран үгийн их чадвартан ингэж хариулах ёсгүй. Тэгэхээр сурвалжлагчийн алдаа байж таарна. Бас «Дээдсийн түлхүүрийн нүхээр» гэсэн нэртэй булан хөтөлдөг сонин байх юм. Түлхүүр нүхтэй юу, цоож нүхтэй юу? Үгийг бодлогогүй хэрэглэдгийн харгай энэ юм.

Телевиз, сонины сэтгүүлчид зарим үгийг буруу хэлбэршүүлсээр байгаад уншигч, үзэгчдийн нүд, сэтгэлд хоногшуулж зөв юм шиг болгодог гэм байна. Телевизийн (МУОНТ голлон) сэтгүүлчид «Төрийн тэргүүд» гэж яриад хэвшчихсэн. "Тэргүүн" гэдэг үгэнд олон тооны дагавар залгахад "тэргүүнүүд" болох ёстой. Уламжлалаар бол "Тэргүүн" байтугай «Тэрэг» гэдэг үгийг ч олон тоон дээр "тэргүүд" биш, "тэргэнүүд" гэж бичих нь зөв юм. Учир нь монгол хэл бичигт үгэнд аливаа дагавар залгахдаа өмнөх үгээ тайрч танах ёс байдаггүй, харин ч салгуу бичдэг уламжлалтай билээ.

Орчин цагийн бичиг, ярианд "хэлмээр байна", "тэрний, энэний зүгээс" гэсэн хачин хэллэг хэвшчихээд байхад хэн ч ажиглахгүй, анзаарахгүй болчихжээ. «"Ээжийн чанасан цай" гэдэг дууг дуучин Жавхлангийн зүгээс зориулж байна» (МУОНТ, "Хит", 2007.11.13, Бурмаа) гэхэд Жавхлан биш, түүний байгаа зүгээс өөр нэг хүн ч юм уу, юу ч юм зориулсан мэт сэтгэгдэл төрөх нь гарцаагүй. Монгол хүн буруу ярьж, зөв ойлгодог гэдэгчлэн гөрдөж л ойлгох байх. Телевизийн хөтлөгч ярилцсан зочиндоо «Цаг зав гаргаж хүрэлцэн ирсэнд баярлалаа гэж хэлмээр байна» гэх юм. Хөтлөгч огт баярлаагүйгээр үл барам "баярлалаа" гэж ёс төдий хэлэх эсэхээ ч шийдэж чадахгүй байгаагаа илтгэсэн хэллэг гэж үзэхээс өөр аргагүй.

Хэвлэл мэдээллийн хэл найруулгын алдаа дутагдлыг энэ мэтээр тооцоод байвал хэдэн арван боть ном болно. Гагцхүү яаж засч залруулах вэ гэдэгт л хэргийн гол нь байгаа юм. Дав даруйд хийж хэрэгжүүлэх бололцоотой ажлын

зарим санааг нэмэрлэхийг хүслээ. Энэ ажил нь төрийн бодлого зохицуулалт шаардсан ажил, шинжлэх ухаан, боловсрол, хэвлэл мэдээллийн байгууллага, ажилтнуудын хүрээнд хийж хэрэгжүүлэх ажил гэсэн хоёр шатла-лаар хэрэгжих бололцоотой гэж үзэж байна.

Төр, засгийн зохицуулалтаар дараах ажлыг хийж хэрэгжүүлэх бололцоотой юм. Үүнд:

- Монгол улсын Ерөнхийлөгчийн ивээл дор улс үндэстний аюулгүй байдал, дархлааг хангахад чиглэгдсэн Хэлний бодлого боловсруулах эрдэмтдийн зөвлөл байгуулах,

- Одоо байгаа Төрийн хэлний зөвлөлийг монгол хэлний, гадаад хэлний гэсэн хоёр салбар бүхий Хэлний бодлогын үндэсний зөвлөл болгож өргөтгөх,

- Улсын нэр томъёоны комиссийг дахин байгуулж ажиллуулах,

- Бүх шатны сургуулийн сурах бичиг, шинжлэх ухааны утга зохиолыг хянан найруулах албан бүтэц бий болгох,

- Монгол улсын хэмжээгээр төрийн хэлний бодлогыг хэрэгжүүлэх нэгдсэн журам боловсруулж, төр, олон нийт, соёл боловсрол, бизнесийн байгууллагын нэр, хаяг, албан хуудас зэргийг нэг мөр болгон цэгцлэх арга хэмжээ авах зэрэг болно.

Шинжлэх ухаан, боловсрол, хэвлэл мэдээллийн газруудаас дараах ажлыг хийж хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Үүнд:

- Үндэсний хэлний засаглал, хэлний дархлаажилтын шинжлэх ухааны үндсийг бэхжүүлэхэд чиглэгдсэн үндэсний хөтөлбөр боловсруулах,

- Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан бэлтгэдэг их, дээд сургуулиудын сургалтын төлөвлөгөөнд монгол хэл, уран зохиол, найруулга зүйн хичээлийн цагийг нэмэгдүүлж, дадлага давамгайлсан хэлбэрээр зохион байгуулах,

- Хэвлэл мэдээллийн хэрэгслийн редакторлах уламжлалыг сэргээж,

мэдээллийн хэрэгсэл бүхэн зөвхөн нийтлэл нэвтрүүлгийн хэл найруулгыг цэгцэлж байх үүрэгтэй утга зохиолын ажилтны орон тоог бий болгох,

- Бичгийн болон ярианы хэлний судалгааг идэвхжүүлж, эрдэмтдийн хүчээр зөв бичих зүйн, журамласан болон хэлц үгийн гэх мэт толь бичгүүдийг гаргаж бичиг зохиолд мөрдүүлэх зэрэг ажлыг дав даруй хийх хэрэгтэй байна.

Ишлэл

¹ 2008. Даяаршил-хэлний бодлого-олон нийтийн мэдээллийн хэрэгсэл. УБ. 50 дахь тал.

² Инжиннаши В. Хөх судар. I дэвтэр. 60-61 дэх тал.

³ Гулиранз З. 1973. Эх, түүний бүтэц, тогтолцоо // Монгол хэлний өгүүлбэр зүйн онол, практикийн зарим асуудал. УБ., 57 дахь тал.

⁴ Сүхбаатар Ц. 2001. Эхийн найруулга зүй. УБ., 25 дахь тал.

⁵ Отгонсүрэн Д. 1995. Эх зохиох товч гарын авлага. УБ., 5 дахь тал.

⁶ Федин К. А. 1971. Писатель, искусство, время. М., с. 351.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Зарва М. 1977. Слово в эфире. М.

2. Накорякова К. М. 1982. Редактирование материалов массовой информации. М.

3. Пронин Е. П. 1981. Текстовые факторы эффективности журналистского воздействия. М.

4. Федин К. А. 1971. Писатель, искусство, время. М.

5. Гулиранз З. 1973. Эх, түүний бүтэц, тогтолцоо // Монгол хэлний өгүүлбэр зүйн онол, практикийн зарим асуудал. УБ.

6. 2008. Даяаршил-хэлний бодлого-олон нийтийн мэдээллийн хэрэгсэл. УБ.

7. Инжиннаши В. Хөх судар. I дэвтэр.

8. Отгонсүрэн Д. 1995. Эх зохиох товч гарын авлага. УБ.

9. Отгонсүрэн Д., Сүхбаатар Ц., Баярсүрэн Ц. 1997. Монгол хэлний найруулгын төрөл. УБ.

10. Сүхбаатар Ц. 2001. Эхийн найруулга зүй. УБ.
11. Хасбаатар Ц. 1986. Хянан найруулах эрдэм. УБ.

Summary

The article raises main issue of styles of article, the main lever of impact of mass

media. Moreover, the author has criticized lack of styles and composition of mass media, taken examples of such mistakes as well as corrective measurements. Furthermore, causes of the mistakes have been mentioned and proposed valuable ideas and opinions for pursuing policies of governments regarding language.